

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хамрах хугацаа /2019.01.02 – 2019.12.31/

Улаанбаатар хот

<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэмжих шалгуур үзүүлэлт /тоо, хувь, чанар/</b>	<b>Тухайн жилийн хүрэх түвшин</b>	<b>Хариуцах нэгж, ажилтны нэр</b>	<b>Хугацаа /сар, улирал/</b>	<b>Биелэлт</b>
1	2	3	5	6	7
<b>Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:</b>					
1. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх	Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилт хангагдаж, төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэнэ.	Жилд 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	II улиралд	Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу 7 төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг Нийслэлийн Төрийн Албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлээ.
2. Албан хаагчдын хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх санал гарган шийдвэрлүүлэх	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа сайжран, цалин хөлс нэмэгдэнэ.	Жилд 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	I улиралд	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын А/29 дугаар тушаалаар байгууллагын ажилтан албан хаагчдын хоолны зардлыгөдөрт 5000 төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.
3. Төрийн албан хаагчдын орон сууцны судалгааг шинэчлэн гаргаж, хөнгөлттэй нөхцлөөр баригдах орон сууцанд хамруулахад дэмжлэг үзүүлэх.	Албан хаагчдын амьдрах нөхцөл сайжирна.	Жилд 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал Өмчийн төлөөлөл,	Жилдээ	Энэ онд уг заалтад хамаарах ажил хийгдээгүй болно. 2020 оны төлөвлөгөөнд үргэлжлүүлэн тусгана.
4. Байгууллагад ашиглагдаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцсоны үндсэн дээр шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх арга хэмжээ авах	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, үйл ажиллагаа сайжирна.	Жилдээ 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	II, III улиралд	НӨАУГ-т ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслийн судалгааг шинэчлэн гаргасан. Мөн шинээр компьютер 2 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхгийг худалдан авсан ба, бусад шаардлагатай техник хэрэгсэлд 15.0 сая төгрөгийн өртөг бүхий шинэчлэл хийсэн болно.
5. Албан хаагчийн ар гэрт					Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай

гачигдал тохиолдох, хүндээр өвдөж, урт хугацааны турш ажил хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа сайжирна.	Тухай бүр жилдээ 1-2 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	Жилдээ	хууль болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу ар гэрт нь гачигдал тохиолдсон 6 ажилтан, албан хаагчид 1,700,000 төгрөгийн тэтгэмжийг олгосон байна. Мөн ажлаас чөлөөлөгдсөн 5 албан хаагчид тэтгэмж олгосон.
6. Ганц бие, өрх толгойлсон болон анх шинээр гэр бүл болсон албан хаагчдад эд хөрөнгийн болон санхүүгийн тусламж дэмжлэг үзүүлэх	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа сайжирна.	Жилдээ 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	IV улиралд	Өрх толгойлсон, бага насны хүүхэдтэй урт цагаан үйлчилгээний төвийн 1 ажилтанд 750.000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон.
7. Гэр болон галлагаатай нөхцөлд амьдардаг албан хаагчдын өвөлжилтийн бэлтгэлд тусламж, дэмжлэг үзүүлэх	Ажилтан, албан хаагчдын ажиргаанд дэмжлэг үзүүлнэ.	12 хүнд жилдээ 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал, Н.Уранчимэг	IV улиралд	Гэр болон галлагаатай нөхцөлд амьдардаг 14 ажилтан, албан хаагчдад сайжруулсан түлшний үнийн хөнгөлөлт болох /3.500.000 төгрөг/-ийн тэтгэмж олгосон болно.
8. Гэр хороололд амьдардаг 1 албан хаагчийг сонгон хашаанд нь ногоо, мод тарих, цэцэрлэгжүүлэх, ногоон орчныг бий болгох ажлыг хамтран хэрэгжүүлэх	Ажилтан, албан хаагчдын амьдрах орчин сайжирна.	1 хүнд жилдээ 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал, Н.Уранчимэг	II улиралд	Гэр хороололд амьдардаг ЗСХ-ийн нярав Д.Батбаярын хашаанд мод тарьж, ногоон орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.